



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 30 өдөр

Дугаар A/24

Баян-Овоо

Данс бүртгэлээс хасаж актлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах шилжүүлэх журам", 2022 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 5.11 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 13 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2025 оны A/224 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Орон Нутгийн Өмчийн Газрын 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 2/84 тоот албан бичиг ирүүлсэн зөвшөөрлийн дагуу 65 нэр төрлийн 102 ширхэг 223,569,073 (Хоёр зуун хорин гурван сая таван зуун жаран есөн мянга далан гурван) төгрөгийн ашиглалтын хугацаа дуусч, үлдэх өртөгтэй болсон хөрөнгийг данснаас хасч актлахыг нягтлан бодогч (Д.Энхзул), нярав (Д.Гэрэлтуяа) нарт үүрэг болгосугай.

2. Үндсэн хөрөнгийн бүртгэлд хяналт тавьж, холбогдох тайлан мэдээг танилцуулахыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (М.Ариунгэрэл)-д даалгасугай.

ДАРГА

Д.ГЭРЭЛМАА



020000132